

**“ГРАНД СИСТЕМС” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

№24/01

Огноо: 2024 оны 12 сарын 31

Цаг: 09:00

Байршил: УУлаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржав гудамж 9, Ориент Плаза, 1 давхар, хурлын өрөө

Хурлын дарга: Д.Энхбилэг

Хуралд оролцсон: Тооллогын комиссын гишүүд, Хурал зохион байгуулах комисс, Хувьцаа эзэмшигчид, Хурлын дарга.

“Гранд Системс” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 09:00 цагт нээв.

ХУРАЛ НЭЭВ

Д.Энхбилэг: Өглөөний мэнд. Өнөөдрийн хурлыг Энхбилэг би даргална. Хурлын дэгийг танилцуулав. 2024 оны 12 сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг тооллогын комиссоос танилцуулахыг хүсэж байна.

Тооллогын комисс: Гранд Системс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн бүртгэлийг хийж танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй 3,750,000 ширхэг хувьцаанаас 2,990,304 ширхэг хувьцаа буюу 79.74 хувийг эзэмшигч хувьцаа хуралд оролцсон буюу 79.74 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

Д.Энхбилэг: Хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. ХЭХ-ийн материалыг хувьцаа эзэмшигчдэд БДК-аар дамжуулан илгээж, холбогдох журамд заасны дагуу танилцах нөхцөл боломжоор хангасан тул уншиж танилцсан байгаа байх.

Хэлэлцсэн нь №1:

Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Д.Энхбилэг танилцуулав: Компани нь 2022 оны №9/23 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Компанийн хэлбэрийг өөрчилж, нийтэд санал болгон анх удаа үнэт цаас гаргах шийдвэрийг тус тус гаргасан. Улмаар 2023 оны 9 сарын 04-ний өдөр Монголын хөрөнгийн биржид, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 сарын 28-ны өдрийн №792 тоот тогтоолоор тус тус нийтэд санал болгон гаргах үнэт цаасаа бүртгүүлсэн. Компани нь анхдагч зах зээлийн арилжааг 2024 оны 2 дугаар улиралд амжилттай зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлээд байна. Ийнхүү Компани нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасаа бүртгүүлж, бүртгэлийн нөхцөл болзолыг хангасан тул компанийн дүрэмд зохих өөрчлөлтийг оруулж, шинэчилсэн найруулгыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж байна. Дүрмийн төслийг хурлын материалд хавсаргасан байгаа. Хувьцаа эзэмшигчдийг дүрэмтэй танилцах, ХЭХ-ын материалтай танилцах боломжийг хангаж хувьцаа эзэмшигчдийн брокер дилерийн компаниудад явуулсан. Иймээс уншиж танилцсан гэж бодож байна.

Хэлэлцсэн нь №2:

Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авах

Д.Энхбилэг танилцуулав: Компанийн хэлбэр өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авах шаардлагатай ба тус шийдвэрийг Хувьцаа

эзэмшигчдийн хурлаас тухайлан гаргуулах Улсын бүртгэлийн байгууллагаас тавьсан шаардлагын дагуу хэлэлцүүлэхээр оруулж байна.

Хэлэлцсэн нь №3:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Д.Энхбилэг танилцуулав: Компани нь хувьцаат компани болж байгаатай холбоотой төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгохоор нэр дэвшүүлж байна. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулгыг хурлын материалд хавсаргасан байгаа. Иймээс уншиж танилцсан гэж бодож байна.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комисс:

Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай санал хураалтын дүн:
 - а. **Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - б. **Татгалзсан:** байхгүй
 - с. **Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ шинээр авах тухай санал хураалтын дүн:
 - а. **Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - б. **Татгалзсан:** байхгүй
 - с. **Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай санал хураалтын дүн:

Д /д	ТУЗ-ийн гишүүн	Нэр	Санал
1	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Н.Цэлмэгсайхан	2,990,304
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн	А.Батболд	2,990,304
3	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Р.Тогтохбаатар	2,990,304
4	ТУЗ-ийн ердийн гишүүн	Д.Энхбилэг	2,990,304
5	ТУЗ-ийн ердийн гишүүн	Э.Тэнүүн	2,990,304
6	ТУЗ-ийн ердийн гишүүн	О.Халтар	2,990,304
7	ТУЗ-ийн ердийн гишүүн	Б.Баярмаа	2,990,304
8	ТУЗ-ийн ердийн гишүүн	О.Болд	2,990,304
9	ТУЗ-ийн ердийн гишүүн	Н.Лхамсүрэн	2,990,304

4. Хүчингүй болсон саналын хуудасны тоо: байхгүй

Д.Энхбэлэг: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2025 оны 12 сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав: 1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсугай. 2. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай. 2. ТУЗ-ийн гишүүдийг сонгосугай.

ХУРЛЫН ХААЛТ

Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссынхонд мөн баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан,

Хурлын дарга Д.Энхбилэг

Тэмдэглэл хөтөлсөн:

Э.Баярцэцэг

(тамга)



[Handwritten signature]

[Handwritten signature]